



КАРТ АШИГЛАХ ЗААВАР

ГҮЙЛГЭЭНИЙ ХАНШ

- Картын валютаа өөр валютаар төлбөр тооцоо хийхэд гүйлгээний ханш нь VISA, MasterCard, American Express, Union Pay зэрэг байгууллагын ханш, тухайн төлбөр тооцоог хүлээн авагч банкны дундын ханшаар бодогддог
- Төлбөрийг карт уншуулсан өдрөөр биш, тухайн байгууллага нэхэмжилж авсан өдрийн ханшаар тооцогддог

ГАДААДАД ЗОРЧИХДОО

- Та гадаад орныг зорихоосоо өмнө картын хүчинтэй хугацаа, хэвийн ажиллагааг АТМ болон ПОС машин дээр заавал шалгах
- Хэрэв удаан хугацаагаар гадаад орныг зорих бол картын итгэмжлэлийг нотариатаар баталгаажуулан үлдээх
- Итгэмжлэл үлдээгээгүй бол тухайн орны элчин сайдын яамаар дамжуулан итгэмжлэл илгээх боломжтой
- Гадаадад байхдаа картаа хаях, сунгах тохиолдолд итгэмжлэгдсэн хүн таны өмнөөс банканд хандан үйлчилгээ авах боломжтой
- Бүртгэлтэй утасны дугаар, и-мэйл хаягаа өөрчилсөн бол салбарт хандах эсвэл интернэт банкны "Хувийн мэдээлэл" хэсэгт мэдээллээ шинэчлэх

КРЕДИТ КАРТЫН ХАМРАХ ХУГАЦАА

Кредит картын төрлөөс хамаарч хүү бодогдох өдөр болон төлөлт хийх өдрүүд харилцан адилгүй байдаг. Иймээс өөрийн картын гүйлгээний хуулгад хамрах хугацаа болон бусад мэдээллийг доорх хүснэгтээс харна уу.

Картын төрөл	Картын төлбөр төлөгдөх хугацаа	Төлбөрийн нэхэмжлэх МЕССЭЖ-ээр илгээх хугацаа	Доод болон дээд дүнгээр эргэн төлөлт хийх сүүлийн хугацаа
ЗЭС, ГАН, Ногоон Амекс	Тухайн сарын 2-оос Дараа сарын 1-ний өдөр	Сар бүрийн 2-ны өдөр	Дараа сарын 15-ний дотор төлөлт хийх
Алтан Амекс Алтан мастер	Тухайн сарын 4-өөс Дараа сарын 3-ны өдөр	Сар бүрийн 4-ны өдөр	Дараа сарын 22-ны дотор төлөлт хийх
Платинум Виза Платинум	Тухайн сарын 5-аас Дараа сарын 4-ний өдөр	Сар бүрийн 5-ны өдөр	Дараа сарын 25-ны дотор төлөлт хийх

КРЕДИТ КАРТЫН ТӨЛБӨР ТӨЛӨХ БОЛОМЖУУД

1. Кредит картын төлбөрөө автоматаар төлөх

- Нийт дүнгээр /тухайн сард ашигласан нийт дүн/
 - Эргэн төлөх доод дүнгээр төлөх /картын төрлөөс хамааран тухайн сард ашигласан зээлийн 10-20%/ гэсэн сонголтоос сонгож картын төлбөрийг автоматаар хийх сонголтыг хийснээр банк таны зөвшөөрсөн хугацаагүй хадгаламж болон харилцах данснаас суутгана.
- Жич: Төлбөр суутгах үед дансны үлдэгдэл хүрэлцэхгүй тохиолдолд төлбөр автоматаар суутгагдахгүй гэдгийг анхаарна уу.

2. Смарт банк

Харилцагч та Смарт банкны Applikeйшн татан, гар утсаараа нэвтэрч орсны дараа: Кредит картаа сонгон Төлбөр төлөх хэсгийг сонгон төлөлтөө хийнэ. Та QR кодыг уншуулан смарт банк аппликейшна татаарай.



3. Интернэт банк

Харилцагч та компьютер болон гар утаснаасаа www.egolomt.mn сайтад нэвтэрч Голомт банкны интернэт банканд хандсанаар:

- Кредит картын төлбөр
- Эргэн төлөх дээд болон доод дүн
- Картын хуулга
- Төлбөр төлөх, и код болон пин код авах, интернэт худалдааны эрхээ нээх, хаах зэрэг мэдээлэл болон үйлчилгээг авах боломжтой.

4. Өөртөө үйлчлэх банк буюу CDM (АТМ) ашиглан орлого зарлага, шилжүүлэг хийхдээ анхаарах зүйлс

Өөртөө үйлчлэх банк буюу CDM нь дараах боломжтой:

- Дебит, кредит картанд бэлэн мөнгөөр орлогын гүйлгээ хийх
- Зарлагын гүйлгээ хийх
- Шилжүүлгийн гүйлгээ хийх
- CDM буюу орлого хийдэг бэлэн мөнгөний машинаас ОРЛОГО ХИЙХ цэсийг сонгож кредит картандаа бэлэн мөнгөөр орлого хийх
- ШИЛЖҮҮЛЭГ цэсээр дамжуулан Голомт банкны бусад төрлийн картнаас кредит картанд шилжүүлэг хийн төлөлтөө хийх боломжтой.

АТМ/CDM-р үйлчлүүлэхдээ анхаарах зүйлс:

- АТМ-с картаа авахгүй 25 секунд болоход карт хураагдах
- Орлого болон шилжүүлгийн гүйлгээний хувьд зөвхөн төгрөгийн картаар хийгдэх
- Кредит картын шилжүүлгийн гүйлгээнд бэлэн гүйлгээний хүү бодогдох
- Гадаадын банкны АТМ-д картаа хураалгасан тохиолдолд буцаан авах боломжгүйг анхаарна уу.

5. Салбар тооцооны төв

Харилцагч та өөрт ойр байрлах салбар, тооцооны төвд хандан кредит картын төлбөрөө төлөх боломжтой. Салбарын байршлын мэдээллийг www.golomtbank.com сайтаас болон 1800-1646 лавлах утсаар авах боломжтой.

ДИЖИТАЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ

Дижитал банк /интернэт банк, смарт банк/-ны нууц үг, аюулгүй байдлыг тогтмол хангахдаа дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- Нууц үгээ тогтмол сольж хэвших
- Тоо, тэмдэгт, том, жижиг үсэг хосолсон хамгийн багадаа 8 тэмдэгтийн урттай нууц үгийг сонгох
- Бусдад интернэт банкны хэрэглэгчийн нэр болон нууц үгийг дамжуулахгүй байх
- Интернэт банкны хэрэглэгчийн нэр болон нууц үгийг веб хөтөч дээрээ хадгалахгүй байх
- Сэжиг бүхий хуурамч и-мэйл, мессеж, дуудлагаас сэргийлэх


КАРТЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ДИЖИТАЛААР

Дижитал банкаар карт блоклох, интернэт гүйлгээний эрх нээх, пин код авах, и-код авах үйлчилгээг цаг алдалгүй авах боломжтой.


- Интернэт банк, смарт банкны эрхээр нэвтэрч Карт → Кредит карт/Дебит карт цэсээр орж
 - Карт блок хийх/гаргах
 - И-код авах
 - ПИН код авах
 - Интернэт худалдааны эрх нээх/хаах

Таны картын интернэт гүйлгээний эрх автоматаар нээлттэй олгогдох ба та онлайн гүйлгээ хийх шаардлагагүй бол дараах зааврын дагуу хаах боломжтой.

Интернэт банкаар:



Смарт банкаар:



ПОС машинаар төлбөр тооцоо хийхдээ

- Кассын ажилтан картыг давхар уншуулах, картын дугаарыг тэмдэглэх, ПИН код асуух зэрэг сэжиг бүхий үйлдэл ажиглагдвал гүйлгээ хийхээс татгалзаж, банканд мэдэгдэх
- Гүйлгээний баримтан дээр гарын үсэг зурахаасаа өмнө гүйлгээний дүн, картын дугаар, он сар зөв эсэхийг шалгах
- Гүйлгээг буцаасан тохиолдолд буцаалтын баримтыг авч, хадгалах

АТМ-р гүйлгээ хийхдээ

- Банкны логогүй, харуул хамгаалалтгүй байршсан АТМ-р үйлчлүүлэхгүй байх
- АТМ-д нэмэлт камер, төхөөрөмж байгаа эсэхийг шалган, сэжигтэй санагдсан тохиолдолд үйлчлүүлэхгүй байх
- ПИН кодоо солихдоо өөрт хамааралтай дугаараар солихгүй байх

Онлайнаар худалдан авалт хийхдээ

- Хамгаалалтгүй онлайн сайтын линк /холбоос/ нь улаан өнгөтэй <https://> эсвэл <http://> байдаг тул картын мэдээллээ оруулахгүй байх
- Веб сайт нь дараах лого бүхий нууцлалтай эсэхийг шалгах



- Тухайн веб сайтын нөхцөл, дотоод дүрэм, гэрээтэй сайтар танилцсаны дараа картын мэдээллээ оруулах
- Аливаа бараа үйлчилгээний төлбөр төлөхдөө нэмэлт төлбөртэй үйлчилгээ, тогтмол хураамжтай эсэхийг шалгах
- Картын мэдээллийг шаардсан, өндөр ашиг орлого амласан сэжиг бүхий сайтуудаар үйлчлүүлэхгүй байх /Bitcoin, BlackFriday гэх мэт/

Зөвшөөрөлгүй гүйлгээ гарахаас сэргийлэх

- Дижитал банк /интернэт банк, смарт банк/-аар нэвтэрч өөрийн дансны хуулгыг тогтмол хянах,
- Зарлагын гүйлгээ гарахад мэдэгдэх мэйл, мессеж үйлчилгээг ашиглан, гүйлгээгээ тогтмол хянах
- Картын ПИН кодыг картын хамт хадгалахгүй байх
- Картын ПИН кодоо бусдад хэлэхгүй байх
- ПИН код, и-кодоо тогтмол сольж байх
- ПИН код, и-кодоо солихдоо өөрийн хувийн мэдээллийг ашиглахгүй байх
- Өөрийн төлбөрийн картын зургийг олон нийтийн сүлжээнд байршуулахгүй байх
- Олон улсын картын байгууллагуудаас мэдээлэл алдагдсан картын мэдээгдлийг банканд ирүүлсэн тохиолдолд банкнаас харилцагчийн картаар луйврын гүйлгээ гарах эрсдэлээс сэргийлж картыг хаадаг. Картыг луйврын эрсдэлээс сэргийлж хаасан талаарх мэдээллийг харилцагчийн бүртгэлтэй гар утасны дугаараар холбогдож мэдээлэх ба, харилцагчтай холбогдож чадаагүй тохиолдолд и-мэйлээр мэдээллэнэ.

Зөвшөөрөлгүй гүйлгээ гарсан тохиолдолд

- Дараах сувгуудаар нэн даруй картаа блоклох
 - Дижитал банк – Интернэт болон смарт банк
 - Лавлах төв +976 1800 1646
 - Онлайн туслах – Facebook chatbot messenger
 - Мессеж/Viber +976 9944 1646
 - И-мэйл – mail@golomtbank.com
- Картнаас зөвшөөрөлгүй гүйлгээ гарсан даруйд Харилцагч өөрийн картнаас зөвшөөрөлгүй зарлага гарсан, давхар хасагдсан, асуудалтай гүйлгээ хийгдсэн тохиолдолд гүйлгээ хийгдсэнээс хойш 14 хоногийн дотор банканд мэдэгдэж шалгуулах.



Голомт банк нь картаар хийгдсэн аливаа гүйлгээг сэжигтэй гэж үзвэл таны дугаар, и-мэйлээр нэн даруй холбогдон гүйлгээг баталгаажуулдаг тул та өөрийн хувийн мэдээллийг солигдсон даруйд бидэнд хандан тогтмол шинэчилнэ үү.